

ТҮГЭЭМЭЛ АСУУЛТУУДЫН ХАРИУЛТ

Аль ангиудад, ямар хичээлээр стандартад суурилсан тайланг ашиглах вэ?

Цэцэрлэгээс тав хүртэлх ангийн сурагчдад Англи хэл, Зураг, Байгалийн ухаан, Нийгмийн ухаан, Дуу хөгжим, Биеийн тамирын хичээлүүдээр стандартад суурилсан ахицын тайланг ашиглах болно.

Стандартад суурилсан ахицын тайланг хэдэн удаа гаргадаг вэ?

Цэцэрлэгийн хүүхдүүдэд энэхүү ахицын тайланг жилд хоёр удаа харин нэгээс тавдугаар ангийн сурагчдад улирал тутамд гаргадаг.

Сурагчдын сурлагын түвшинг багш хэрхэн тодорхойлох вэ?

Улирлын туршид багш төрөл төрөл бүрийн арга, тухайлбал бичгийн шалгалт, төсөлт ажил, тест, таавар, бүтээлч даалгавар болон ажиглалт зэргийг ашиглан сурагчдын ахицыг тодорхойлох баримт цуглуулах бөгөөд эдгээрт үндэслэн үнэлгээг хийнэ.

Энэ нь сурагчдад ямар ашигтай вэ?

Сурагчид олж авах ёстой ур чадвар, үндсэн ойлголтуудынхаа талаар тодорхой ойлголттой болно. Эцэг эхчүүд хүүхдийнхээ сайн эзэмшсэн агуулга, эсвэл хоцрогдож буй талуудыг олж мэдсэний үндсэн дээр анхаарч ажиллах боломжтой болно.

Стандартад суурилсан ахицын тайланг одоогоор бид бага ангийн түвшинд хэрэгжүүлж байгаа бөгөөд цаашид энэ талаар эцэг эхчүүд болон бусад талуудын саналыг анхаарч ажиллах болно.

Стандартад суурилсан сургалт, түүнийг хэрхэн дүгнэж, ахицын тайланг гаргах талаарх мэдээллийг доорх сайтаас авна уу:

<https://www.apsva.us/curriculum/standards-based-grading/>

Стандартад суурилсан сургалт, түүнийг хэрхэн дүгнэж, ахицын тайланг гаргах талаар нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл Сургалтын Албаны Захирал Kerri Hirsch-тэй kerri.hirsch@apsva.us цахим шуудангаар харилцана уу.

Syphax Education Center
2110 Washington Blvd. Arlington, VA 22204

БАГА СУРГУУЛИЙН СТАНДАРТАД СУУРИЛСАН АХИЦЫН ТАЙЛАН



ЭЦЭГ ЭХЧҮҮДЭД ЗОРИУЛСАН ГАРЫН АВЛАГА

Стандартад суурилсан тайлангаар эцэг эх/асран хамгаалагчид хүүхдийнхээ Виржини мужийн Сурлагын Стандарт болон АТӨС-ийн анги тус бүрт эзэмшвэл зохих хичээлийн жишиг мэдлэгт суурилсан суралцах үйл явцын ахицын талаарх мэдээлийг олж харах боломжтой юм.

Энэхүү ахицын тайлан нь сурагчдын сурлагын амжилт болон цаашид хөгжих нөөц боломжийг тодотгон харуулах болно.

ОРШИЛ

АТӨС нь стандартад суурилсан ахицын тайланг 21 бага сургуулиудад нэвтрүүлээд байна. Ахицын тайлангийн энэхүү шинэ хэлбэр нь сурагчдын олж авч буй шинэ ур чадвар, мэдлэгийн талаар илүү дэлгэрэнгүй мэдээллийг агуулах болно.

Стандартад суурилсан тайлангаар тэдний олж авч буй мэдлэгийг уламжлалт үсгэн аргаар дүгнэхгүй. Стандартад суурилсан үнэлгээний арга нь:

- Багшлах, суралцахуйн үйл явцтай илүү уялдаатай
- Сурагчдын бодит мэдлэг, чадварыг харуулахад чиглэнэ
- Ахицын талаар илүү тодорхой мэдээлэл агуулна
- Сурагчдыг оролцуулна.

АТӨС-ийн сургалтын үйл явцад ашигладаг сургалт семинарын загварчлал, тусгай эргэх холбоо болон зорилтот сургалтын арга зэрэг нь энэхүү зорилгыг дэмжиж байгаа юм. Сурагчид зорилгоо өөрсдөө тодорхойлж, стандартыг бүрэн эзэмшихийг хичээж, гаргаж буй ахицынхаа талаар эргэцүүлэх болно.

СТАНДАРТАД СУУРИЛСАН АХИЦЫН ТАЙЛАНД ЯАГААД ШИЛЖИХ БОЛОВ?

- **Илүү утга учиртай:** Стандартад хүрэхээр суралцаж буй сурагчийн ахицын талаар илүү нарийвчилсан тодорхой мэдээллийг агуулна.
- **Бодит зөв үнэлгээ:** Сурагчдын мэдэж буй агуулгуудыг үнэн бодитоор харуулсан үнэлгээ
- **Тууштай байдал:** Сурагчдыг дүгнэх явц дахь хувь хүний нөлөөг арилгаснаар сурлагын ахицыг бодитоор таамаглах нөхцөл бүрдэнэ
- **Сурлагын бодит дэмжлэг:** Багш нарын санал сэтгэгдэлд үндэслэж сургалтын үйл явцыг сурагчдын хэрэгцээнд тулгуурлан өөрчлөх боломжтой

АХИЦЫН ШИНЭ ТАЙЛАН ЯМАР БАЙХ ВЭ?

Хичээл бүрээр Виржиниагийн стандарт болон стандартын дагуу эзэмшсэн талаарх зэрэглэлийг тусгана. Нийгэмших болон бусад ажлын ур чадваруудыг бас тусгах болно. Үсгээр илэрхийлдэг үнэлгээний оронд стандарт үзүүлэлттэй харьцуулах таны хүүхдийн ахицыг харуулах болно. Түвшин бүрийг доор тайлбарласан болно.

АТӨС-ийн СТАНДАРТАД СУУРИЛСАН АХИЦЫН ТАЙЛАН СУРЛАГЫН ТҮВШИН

- **Стандартыг бүрэн хангаж буй:** Сурагч стандарт түвшнийг бүрэн эзэмшиж, бие даасан ойлголттой болсныг илтгэнэ.
- **Стандартыг бүрэн хангахад дөхсөн:** Сурагч стандарт түвшнийг тодорхой хэмжээнд эзэмшиж, бүрэн бие даасан ойлголт хараахан суугаагүйг илтгэнэ.
- **Стандарт хангахаар суралцаж буй:** Сурагч стандартын үндсэн ойлголтыг бусдыг тусламжтайгаар авч чадна.

